



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/91

Улаанбаатар хот

**Мал эмнэлгийн төлөвлөгөөт
арга хэмжээг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6, 7, 9, 15 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 41-р зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2026 оны А/16 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/274 дүгээр захирамж, Нийслэлийн мал эмнэлгийн газрын даргын 2026 оны А/25 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн нутаг дэвсгэрт байгаа мал, амьтныг гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 2026 оны төлөвлөгөөт арга хэмжээ, мөн шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээ, лабораторийн шинжилгээний хүрээнд хэрэгжүүлэх ажлыг 2026 оны 4 дүгээр сарын 02-ны өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдрийн хугацаанд зохион байгуулсугай.

2.Харьяа нутаг дэвсгэрт байгаа мал, амьтныг гоц халдварт, халдварт болон шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, тарилга, вакцинжуулалт, угаалга, туулгалт, боловсруулалтын төлөвлөгөөт ажилд малчид болон мал бүхий өрхийг бүрэн хамруулах, мал эмнэлгийн тасгаас гаргасан дархлаажуулалтын товын дагуу бэлэн байлгаж, зарлан мэдээлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг хороодын Засаг дарга (Н.Нямзав, Б.Батзориг) нарт, Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд товлосон хугацаанд мал, амьтнаа бэлэн байлгаж, бүрэн хамруулахыг малчин, мал бүхий иргэдэд, 2026 оны мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээг товлосон хугацаанд холбогдох заавар, журмын дагуу хэрэгжүүлэхийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж ЦЭФ трейд ХХК (А.Цэрэндагва)-д, Шаардагдах вакцин, эм, био бэлдмэлийг татан авч хуваарилан хүргүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж зохион байгуулан тайлагнахыг Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

3.Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг нэгдүгээр, лабораторийн шинжилгээнд хамрагдах мал, амьтны төлөвлөгөөг хоёрдугаар, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг гуравдугаар, мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээний шатахууны зардлын тооцоог дөрөвдүгээр, шаардагдах зардал олгох хуваарыг

тавдугаар, дүүргийн нутаг дэвсгэрт мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээ явуулах замын маршрутыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.Шаардагдах 4,657,150 (Дөрвөн сая зургаан зуун тавин долоон мянга нэг зуун тавь) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт худалдаа, үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
 2026 оны 04 дугаар сарын 30 ны өдрийн
 А/С/ дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГЖ ЦЭФ ТРЕЙД ХХК-НИЙ 2026 ОНД МАЛ,
 АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ, ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА
 ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээний төрөл		Хамрагдах мал, амьтны тоо /мян.тол/				Зарцуулах бэлдмэл	
			Бод	Бог	Амьтан	Бүгд	Шингэн /литр/	Хатаасан /мян.тун/
0	1		2	3	4	5	6	7
Улсын төсвөөс санхүүжих								
1	Боом	Вакцин	1200	4000		5200		
2	Галзуу	Вакцин	1000	3000	200	4200		
3	Гахайн мялзан	Вакцин			100	100		
4	Цусан халдвар /2 удаа/	Вакцин	500	2000		2500		
5	ДХХ, эниеробактериоз /2 удаа/	Вакцин		4000		4000	28.0	
6	Дуут хавдар	Вакцин	1500			1500	7.5	
Бүгд			4200	13000	300	17500	74.2	4.3
Иргэн хуулийн этгээдээс санхүүжүүлэх								
5	Сахуу	Бактери н	500			500	0.5	
6	Шөвөг яр	Вакцин		300		300		0.3
7	Шөвөг ярын шингэлэгч						0.03	
Бүгд			500	300		800	0.53	
Нийт дүн			4700	13300	300	18300	74.73	4.6

Эрүүл мэндийн үзлэг хийх


№	Малын төрөл	Өрхийн тоо
1	Бод	25
2	Бог	25
Нийт дүн		50

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 дугаар сарын 30 ны өдрийн
151 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

2026 ОНД ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНД ХАМРАГДАХ МАЛ,АМЬТНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээний нэр	Хамрагдах мал,амьтны тоо			
		Бүгд	Бод	Бог	Амьтан
1	Бруцеллёзын шинжилгээ	115	25	90	
2	Бруцеллёзын цагирган урвал	300	300		
3	Ямын шинжилгээ	100	100		
	Дүн	515	425	90	

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны ... дугаар сарын ... ны өдрийн
... дугаар захирамжийн гуравдугаар хавсралт



2026 ОНД ШИМЭГЧТЭХ ӨВЧНӨӨС ЭМЧЛЭН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээний нэр, төрөл	Хамрагдах мал, амьтан /мян.тол/
1	Туулгалт бод	2.0
2	Туулгалт бог	8.0
3	Туулгалт амьтан	0.1
4	Угаалга бод	1.5
5	Угаалга бог	12.0
6	Боловсруулалт бод	2.0
7	Боловсруулалт бог	12.0
	Нийт	37.6

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 10 дугаар сарын 30 ны өдрийн
А/С/1 дугаар захирамжийн дөрөвдүгээр хавсралт

МАЛ ЭМНЭЛГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ШАТАХУУНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн нэр	Машины марк	Шатахууны төрөл / л/	Явах км	Шаардагдах хэмжээ /л/	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	ЦЭФ трейд ХХК	Прадо-120 77-89 УНЦ	АИ-92 /15л/	4200	520	2590	1.346.800
2	Мал эмнэлгийн тасаг	Sonata VII 64-96 УНӨ	АИ-92 /12л/	3000	250	2590	647.500


ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, ХАЛДВАР ХАМГААЛАЛЫН ХУВЦАС, ЗҮҮ ТАРИУРЫН
ЗАРДЛЫН ТООЦОО

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	1 удаагийн хамгаалах хувцас	ширхэг	50	18.000	900.000
2	Хөдөлмөр хамгааллын хувцас	ширхэг	2	160.000	320.000
3	Шиприц /10гр/	ширхэг	3200	500	1.600.000
4	Зүү №-12, №-16	ширхэг	2000	1000	2.000.000

АЖИЛЛАХ ХҮН ХҮЧНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Ажиллах албан тушаалын нэр	Ажиллах хүний тоо	Ажиллах хоног	1 өдрийн хөлс	Бүгд үнэ
1	Туслах ажилтан	2	25	50000	2.500.000
Нийт дүн					9.314.300


Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 дугаар сарын 30 ны өдрийн
179/.... дугаар захирамжийн тавдугаар хавсралт



ШААРДАГДАХ ЗАРДАЛ ОЛГОХ ХУВААРЬ

№	Нэгжүүдийн нэр	5-р сар	10-р сар	Нийт зардалд
1	ЦЭФ трейд ХХК	4.333.400	4.333.400	8.666.800
2	Мал эмнэлгийн тасаг	323.750	323.750	647.500
	Бүгд	4.657.150	4.657.150	9.314.300

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 дугаар сарын 30 ны өдрийн
4191 дугаар захирамжийн зургаадугаар хавсралт



ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ МАЛ ЭМНЭЛГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТ
АРГА ХЭМЖЭЭ ЯВУУЛАХ ЗАМЫН МАРШРУТ

№	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, байгууллагын нэр	Явах газрын зураглал
1	ЦЭФ трейд ХХК	Дүүргийн 1,2-р хорооны , Үнэгтэй, Алтагана, Хээхрийн хоолой, Гашууны дэрс, Бор толгой, 5-ын гүүр, Балжирын энгэр, Агуйт, Өндөр толгойн өвөр, Хашаат, Чулуут, Полигион, Хадат, Балжирын энгэр, Үйлдвэрийн бүс, Хайрхан зөрлөг, Цагаан хяр, Хоолтын өвөр, Шинэ суурьшилын бүс, Бор үзүүр, Цайдам, Нуурын хороолол, Замчин, Төмөр толгой, Хангай зөрлөг, Хуурай худаг, Цантын ар, Хужирын ухаа, Алсын худаг, Жононгийн нуур, Айраг нуур гэсэн маршрутаар 8 удаа нийт 4200 км явна
2	Мал эмнэлгийн тасаг	Мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээний явц гүйцэтгэлийн хяналт, хэрэглэсэн эм био бэлдмэлийн тун хэмжээ, хадгалалт, тээвэрлэлтийн горим, зарцуулалтын хяналт, малын шилжилт хөдөлгөөн, отор нүүдэлд хийх хяналт, тандалтын сорьц цуглуулах үйл ажиллагааг заавар төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байгаа эсэхийг хянах, эрсдэлийн үнэлгээний удирдамжийн дагуу малчин өрхийг оновчтой зөв сонгож үнэн зөв мэдээлэл бүрдүүлсэн эсэхэд хяналт тавих зэргээр Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, түүнийг дагалдан гарсан журам, заавар стандартын хэрэгжилт, мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх нэгдсэн бодлогын хэрэгжилтийг хангуулж ажиллахад 3000 км явна